



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/470

Ховд

Нийтийг хамарсан зарим
арга хэмжээг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", 29.1.6-ын "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн хэмжээнд нийтийг хамарсан хурим найр, цайллага зохион байгуулахыг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хориглосугай.
2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ